СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас:  90098901
Цахим хаяг: coo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........................ 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........................ 10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........................ 10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........................ 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................ 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................ 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........................ 13
**4.1 Ерөнхий зүйл** ........................ 13
**4.2 Материаллаг байдал** ........................ 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........................ 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........................ 14
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........................ 15
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........................ 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........................ 15
**5.1 Төлбөрийн акт** ........................ **Error! Bookmark not defined.**
**5.2 Албан шаардлага** ........................ **Error! Bookmark not defined.**
**5.3 Зөвлөмж** ........................ 16
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........................ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани |

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 102

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ЭНХСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 313,246.7 мянган төгрөг буюу 23.8 хувиар өссөн нь 19,131.8 мянган төгрөгийн тоглоомын талбай сайжруулсан, 12,051.3 мянган төгрөгийн ухаалаг самбарын 70 хувь болох 8,435.9 мянган төгрөгийг БШУ-ны яамнаас олгосон, сум орон нутгийн төсвөөс 67,756.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандив тусламжаар хүлээн авсан нь нөлөөлсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **81,468,894.43** | **134,504,910.71** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 39,999,823.30 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 39,999,823.30 |
| **3121** | **Төгрөг** | - | 39,999,823.30 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 39,999,823.30 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 81,468,894.43 | 94,505,087.41 |
| **351** | **Түүхий эд материал** | 80,148.00 | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 80,148.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 81,388,746.43 | 87,705,087.41 |
| 35420 | Аж ахуйн материал | 93,500.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | - | 120,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 14,708.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 81,280,538.43 | 87,585,087.41 |
| 35600 | Мал амьтад | - | 6,800,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,227,477,663.31** | **2,226,133,900.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,227,477,663.31 | 2,226,133,900.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,201,463,663.31 | 2,185,235,900.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,300,489,889.45 | 2,281,969,158.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (240,245,680.81) | (280,657,460.44) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20,500,000.00 | 20,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (18,506,944.30) | (20,500,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 210,173,157.00 | 146,381,922.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (152,572,074.30) | (71,110,556.22) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 136,015,851.00 | 107,971,300.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (86,405,568.13) | (28,458,843.31) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 105,594,700.00 | 105,594,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (98,335,933.41) | (103,844,300.44) |
| 39217 | Ном | 24,756,266.81 | 27,389,979.81 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,014,000.00 | 40,898,000.00 |
| 39301 | Програм хангамж | - | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (50,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,789,000.00 | 39,448,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (775,000.00) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,308,946,557.74** | **2,360,638,810.91** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **56,418,133.00** | **1,990,500.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 56,418,133.00 | 1,990,500.00 |
| **413** | **Өглөг** | 56,418,133.00 | 1,990,500.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 56,051,863.00 | 1,990,500.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,252,528,424.74** | **2,358,648,310.91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,252,528,424.74 | 2,358,648,310.91 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 449,054,291.40 | 449,054,291.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 449,054,291.40 | 449,054,291.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,266,087,230.99 | 1,372,207,117.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,286,096,281.56 | (1,042,859,326.75) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (20,009,050.57) | 2,415,066,443.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 537,386,902.35 | 537,386,902.35 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,308,946,557.74** | **2,360,638,810.91** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,004,697,163.54** | **3,626,890,381.22** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **132,460,727.54** | **2,437,062,224.22** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 132,460,727.54 | 2,437,062,224.22 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 132,460,727.54 | 2,437,062,224.22 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,312,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 12,250,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 132,460,727.54 | 2,422,500,124.22 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **872,236,436.00** | **1,189,828,157.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 767,437,700.00 | 955,845,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 955,845,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 767,437,700.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,246,536.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 603,236.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,643,300.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 102,552,200.00 | 233,982,657.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 102,552,200.00 | 233,982,657.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,024,706,214.11** | **1,205,736,918.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,024,706,214.11** | **1,205,736,918.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 993,068,683.11 | 1,136,464,570.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 604,009,449.00 | 683,040,243.70 |
| 210101 | Үндсэн цалин | 422,036,791.13 | 475,521,832.94 |
| 210102 | Нэмэгдэл | 128,656,334.55 | 165,527,576.76 |
| 210104 | Урамшуулал | 53,316,323.32 | 41,990,834.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,460,000.00 | 96,274,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,908,400.00 | 65,466,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,387,900.00 | 7,702,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,310,300.00 | 6,161,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,077,600.00 | 1,540,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,775,800.00 | 15,403,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 139,593,880.00 | 135,415,478.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,221,945.00 | 10,100,328.31 |
| 210302 | Түлш, халаалт | 132,044,935.00 | 124,815,349.69 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,327,000.00 | 499,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,562,777.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,463,677.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 794,800.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,036,700.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 364,700.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 311,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,591,900.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 29,344,368.00 | 42,913,428.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,913,800.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 23,082,768.00 | 42,913,428.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,347,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,997,870.00 | 4,426,359.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,997,870.00 | 4,426,359.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 518,400.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 518,400.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,337,451.00 | 5,114,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,337,451.00 | 2,312,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 2,802,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 126,244,488.11 | 169,280,161.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 30,649,741.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,198,800.00 | 14,085,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 122,045,688.11 | 124,544,720.35 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,637,531.00 | 69,272,348.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,617,050.00 | 69,272,348.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,034,800.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,582,250.00 | 59,274,748.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,997,600.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,020,481.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,020,481.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(20,009,050.57)** | **2,421,153,462.67** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 6,087,018.76 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 6,087,018.76 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (6,087,018.76) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(20,009,050.57)** | **2,415,066,443.91** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **872,236,436.00** | **1,204,390,257.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **14,562,100.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 14,562,100.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 14,562,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,312,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 12,250,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **872,236,436.00** | **1,189,828,157.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 767,437,700.00 | 955,845,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 955,845,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 102,552,200.00 | 233,982,657.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 102,552,200.00 | 233,982,657.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **864,576,436.00** | **1,146,443,852.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **864,576,436.00** | **1,146,443,852.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **833,078,757.00** | **1,073,914,632.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 604,914,094.00 | 683,352,513.70 |
| 210101 | Үндсэн цалин | 422,941,436.13 | 475,834,102.94 |
| 210102 | Нэмэгдэл | 128,656,334.60 | 165,527,576.76 |
| 210104 | Урамшуулал | 53,316,323.27 | 41,990,834.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,460,000.00 | 96,274,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,908,400.00 | 65,466,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,387,900.00 | 7,702,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,310,300.00 | 6,161,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,077,600.00 | 1,540,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,775,800.00 | 15,403,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,552,200.00 | 191,467,341.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,221,945.00 | 10,100,328.31 |
| 210302 | Түлш, халаалт | 90,003,255.00 | 180,867,212.69 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,327,000.00 | 499,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 29,210,676.00 | 39,615,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,949,076.00 | 39,615,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,390,000.00 | 4,546,359.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,546,359.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,337,451.00 | 8,502,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,337,451.00 | 2,312,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 6,190,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,198,800.00 | 50,155,919.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 36,070,219.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,198,800.00 | 14,085,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,497,679.00** | **72,529,220.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,477,198.00 | 72,529,220.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,442,398.00 | 62,531,620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,997,600.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,020,481.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,020,481.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,660,000.00** | **57,946,404.30** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **17,946,581.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **17,946,581.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 17,946,581.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 17,946,581.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(17,946,581.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 7,660,000.00 | 39,999,823.30 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 39,999,823.30 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 449,054,291.40 | 537,386,902.35 | 1,286,096,281.56 | 2,272,537,475.31 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 20,009,050.57 | 20,009,050.57 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **449,054,291.40** | **537,386,902.35** | **1,306,105,332.13** | 2,292,546,525.88 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **449,054,291.40** | **537,386,902.35** | **1,306,105,332.13** | 2,292,546,525.88 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (2,308,946,557.74) | (2,308,946,557.74) |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **449,054,291.40** | **537,386,902.35** | **(1,002,841,225.61)** | (16,400,031.86) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,415,066,443.91 | 2,415,066,443.91 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **449,054,291.40** | **537,386,902.35** | **1,412,225,218.30** | 2,398,666,412.05 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,237,426,800.00 | 1,164,390,433.70 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,237,426,800.00 | 1,164,390,433.70 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,161,949,800.00 | 1,091,861,213.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 720,404,600.00 | 683,352,513.70 |
| 210101 | Үндсэн цалин | 539,640,000.00 | 475,834,102.94 |
| 210102 | Нэмэгдэл | 163,432,600.00 | 165,527,576.76 |
| 210104 | Урамшуулал | 17,332,000.00 | 41,990,834.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 96,274,300.00 | 96,274,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,466,500.00 | 65,466,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,702,000.00 | 7,702,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,161,600.00 | 6,161,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,540,400.00 | 1,540,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,403,800.00 | 15,403,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 220,556,100.00 | 191,467,341.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,200,000.00 | 10,100,328.31 |
| 210302 | Түлш, халаалт | 209,106,000.00 | 180,867,212.69 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,250,100.00 | 499,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,615,700.00 | 39,615,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,615,700.00 | 39,615,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.00 | 4,546,359.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,546,359.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,002,500.00 | 10,002,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,312,100.00 | 2,312,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,690,400.00 | 7,690,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 70,096,600.00 | 66,602,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,010,900.00 | 52,516,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,085,700.00 | 14,085,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 75,477,000.00 | 72,529,220.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 75,477,000.00 | 72,529,220.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 65,479,400.00 | 62,531,620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,997,600.00 | 9,997,600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,219,370,700.00 | 1,189,828,157.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,219,370,700.00 | 1,189,828,157.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,219,370,700.00 | 1,189,828,157.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын үйл ажиллагаа явуулдаг БШУ-ны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь төрийн үйлчилгээний байгууллага бөгөөд суралцагчдын сурлагын болон сурах арга барилыг сургалтанд нэвтрүүлэх зорилготой.

Сурагчдын агуулгын болон сурах арга барилын хоцрогдлыг оношлох, сургуулийн цахим хичээлийн санг баяжуулж, суралцагчдын цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлэх, агуулгын хоцрогдлыг бууруулж, гүйцэтгэлийг 25 хувиар ахиулах, хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай суралцах, хөгжихөд нь тасралтгүй дэмжлэг үзүүлэх, багшийн хандлага, хувь хүний хөгжил, арга зүй, мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлээр хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай"
- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот "Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах"
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал "Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай"
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөөг дунд зэрэг байна гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримталын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа улсын секторын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,692.3 мянган төгрөгөөр буюу 2.24 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 39,999.8 | 39,999.8 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 81,468.9 | 94,505.1 | 13,036.2 |
| Үндсэн хөрөнгө | 2,227,477.7 | 2,226,133.9 | -1,343.8 |
| **Нийт хөрөнгө** | **2,308,946.6** | **2,360,638.8** | **51,692.3** |
| Өр төлбөр | 56,418.1 | 1,990.5 | -54,427.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,252,528.4 | 2,358,648.3 | 106,119.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,308,946.6** | **2,360,638.8** | **51,692.3** |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,226,133.9 мянган төгрөг болж,1,343.8 мянган төгрөгөөр буюу 0.06 хувиар буурч, бараа материалын үлдэгдэл 94,505.1 мянган төгрөг болж 13,036.2 мянган төгрөгөөр буюу 16.0 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,622,193.2 мянган төгрөг буюу 261 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Тухайн өсөлт нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой бүртгэлийн тохируулга байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 181,030.7 мянган төгрөгөөр буюу 17.67 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл цалин, бусад бараа үйлчилгээний зардал бөгөөд үнийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдсэн байна. Цалингийн зардал 79,030.8 мянган төгрөгөөр, хүүхдийн үдийн цай хөтөлбөр болон бусад бараа үйлчилгээ 73,727.9 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 973,901.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 263,525.1 мянган төгрөг, нийт зарлагыг 1,237,426.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,237,426.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,164,390.4 мянган төгрөгийн буюу 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 3,076.20 | 3,076.20 | - | 100% |
| 2 | 80312 | Сургалт семинар | 1,538.10 | 1,538.10 | - | 100% |
| 3 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 3,537.60 | 3,537.60 | - | 100% |
| 4 | 81801 | Үдийн цай хөтөлбөр | 65,479.40 | 62,531.60 | 2,947.80 | 95% |
| 5 | 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 56,610.80 | 50,897.80 | 5,713.00 | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 81816 | Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 16,485.00 | 16,485.00 | - | 100% |
| 7 | 81823 | Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр | 6,921.40 | 6,921.40 | - | 100% |
| 8 | 81834 | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөр | 713,148.00 | 708,695.00 | 4,453.00 | 99% |
| 9 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 89,049.00 | 62,163.00 | 26,886.00 | 70% |
| 10 | 81844 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах | 13,194.10 | 9,700.00 | 3,494.1 | 100% |
| 11 | 81848 | Сурах бичгийн түрээс | 2,312.10 | 2,312.10 | - | 100% |
| 12 | 83603 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 2,550.00 | 2,550.00 | - | 100% |
| 13 | 80111 | Байр ашиглалтын үйлчилгээ | 225,556.10 | 196,013.70 | 29,542.4 | 87% |
| 14 | 80112 | Нийтлэг үйлчилгээ | 37,969.00 | 37,968.96 | 0.04 | 100% |
| | | | 1,237,426.80 | 1,164,390.40 | **73,036.3** | 94% |

Батлагдсан төсөв гүйцэтгэлийн зөрүү 73,036.4 мянган төгрөг байна. Үүний 39,999,8 мянган төгрөг нь зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл бол 33,036.5 мянган төгрөг олгогдоогүй санхүүжилтийн дүн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 14,562.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Миндүг Аудит" ХХК-ны /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах М.Уламбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 10,247.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,685.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд бараа үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой гэж үзэж байна. Нийт батлагдсан төсвөөс 39,999.8 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан нь дансны үлдэгдлийн баталгаагаар нотлогдож байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;
[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 102 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 11 мэдээллийг хугацаа хоцроосон, 6 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуульд завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 1,103,825.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,097,972.3 мянган төгрөгийн залруулга хийж, 574.0 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож бүрэн биелүүлсэн, 5,278.9 мянган төгрөгийн 1 зөрчилд өгсөн албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай биелсэн байна.

Зөвлөмжөөр өгсөн элэгдлээр өртгөө нөхсөн 159 нэр төрлийн 175,043.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авч данснаас хасах зөвлөмж өгсөн. Актлаж, данснаас хасах саналыг аймгийн ОНӨГ-т хүргүүлж шийдвэрийн дагуу зөрчлийг арилгаж, зөвлөмжийг биелүүлсэн байна.

*Хүснэгт 3. Албан* шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 574.0 | 1 | 574.0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 5,278.9 | 1 | 5,278.9 | 100 |
| Зөвлөмж | 3 | 1,097,972.3 | 2 | 1,097,972.3 | 100 |
| **Нийт дүн** | 5 | 1,103,825.2 | 2 | 1,103,825.2 | 100 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аливаа акт, албан шаардлага хүргүүлэх асуудлууд илрээгүй бөгөөд худалдах, худалдан авах гэрээний дүн дутуу шилжүүлсэн бөгөөд гэрээний үлдэгдэл дүнг дансны өглөгөөр бүртгээгүйг санхүүгийн тайланд залруулсан ба Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Алдааны залруулга

*Илрүүлэлт*: Худалдан авах гэрээний төлбөрийн урьдчилгааг шилжүүлсэн ба үлдэгдэл дүн болох 1,990.5 мянган төгрөгийг дансны өглөгөөр бүртгээгүй байна.

*Залруулга:* Илрүүлэлтийн дагуу тайландаа засвар хийж 1,990.5 мянган төгрөгийг өглөгөөр тусгуулав.

### 5.2 Зөвлөмж

***1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт: Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 102 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 11 мэдээллийг хугацаа хоцроосон, 6 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.*

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан хугацаанд мэдээлэх;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авах гэрээний төлбөрийн урьдчилгааг шилжүүлсэн ба үлдэгдэл дүнг дансны өглөгөөр бүртгээгүй | 1 | 1,990.5 | | | | | 1 | 1,990.5 | | | | |
| Нийт дүн | 1 | 1,990.5 | - | - | - | - | 1 | 1,990.5 | - | - | | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

**/мянган төгрөгөөр/**

| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| *Хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн* | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт дүн** | - | - | - | - | - | - | - | - |